

ТАНИЛЦУУЛГА

Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний
аж ахуйн нэгж байгууллагуудад
хяналт шалгалт хийсэн тухай

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Зам, тээврийн яамнаас 2016 оны 01/35 дугаар бүхий албан бичиг/ЗТЯ-нд УБ – Завхан аймгийн Тосонцэнгэл сум – УБ чиглэлд хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Жигд эргэл” ХХК-ийн гэрээт тээвэрлэгч жолооч нараас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тухайн компанийн үйл ажиллагаанд Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын дарга Б.Жаргалын баталсан 2015 оны 038-07-003/70 тоот удирдамжийн дагуу хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал арилгуулах тухай/-ээр хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлт, “Жигд эргэлт” ХХК-иас ирүүлсэн “Дорнын саруул зам” хоршооны үйл ажиллагааны талаарх гомдлыг шалгаж, дүгнэлт гаргах зорилгоор тус яамны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 38-07-003, 077/08 дугаар бүхий удирдамжийн дагуу автозамын зорчигч тээврийн хяналт хариуцсан мэргэжилтэн, автотээврийн хяналтын улсын байцаагч/АТХУБ/ Э.Оюунтунгалаг, мэргэжилтэн АТХУБ Б.Оюунцэцэг, Завхан аймгийн Автотээврийн төвийн АТХУБ Б.Ганболд нар шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан хяналт шалгалт хийлээ.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн хугацаа

2016 оны 03 дугаар сарын 15-22-ны /ажлын 5 хоногт/ өдрүүдэд.

Гурав. Шалгалтад хамрагдсан объект

“Жигд эргэлт” ХХК, “Дорнын саруул зам” хоршоо.

Дөрөв. Хяналт шалгалтаар хийсэн ажил

1. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлтийн гэрээний үүргийн биелэлт, зам, тээврийн осол, зөрчил, үйлчилгээний талаар иргэдээс ирүүлсэн санал, гомдлын талаарх мэдээллийг “Автотээврийн үндэсний төв” ААТТӨҮГ-аас авч судлав.

2. “Жигд эргэлт” ХХК-д Зам, тээврийн яамнаас 01/35 дугаар бүхий албан бичиг өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгалаа.

3. “Жигд эргэлт” ХХК-д 2015 онд 038-07-003/70 тоот удирдамжийн дагуу хийгдсэн шалгалтаар шалгалтаар тогтоосон компаниудын эрсдэлийн үнэлгээнд тодотгол хийж эрсдэлийн түвшинг нь дахин тогтоолоо.

4. “Дорнын саруул” хоршооны үйл ажиллагааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 540 дүгээр тушаалаар батлагдсан “Нийтийн тээврийн байгууллагыг шалгах 5.21 кодтой хяналтын хуудас”-аар шалгаж, эрсдэл тогтоосон.

5. “Жигд эргэлт” ХХК-иас ирүүлсэн тухайн хоршооны тээвэрлэлтийн явцад гаргасан 02 дугаар сарын 07, 10-ны өдрийн шугам замын таслалт нь хоршооны буруутай ажиллагаанаас болсон тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу хоршооны дарга Ч.Алтаннямд хариуцлага тооцсон.

А. Боловсон хүчин, материаллаг бааз, тээврийн хэрэгслийн хангалт холбогдох хууль, тогтоомж, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахад:

• Шалгуулагч байгууллагуудын зэргийг 2011 оны ЗТБХБСайдын 153 дугаар зөвлөмжийн дагуу хөдлөх бүрэлдэхүүний шилжүүлэх коэффициентийг ашиглан тогтооход автотээврийн аж ахуйн нэгж, байгууллагын зэрэг тогтоох боломжгүй, автогараашийн зохион байгуулалтай байна.

❖ **“Жигд эргэлт” ХХК**

Захирал Ч.Борбаатар – “Нягтлан бодох бүртгэл” мэргэжилтэй

Гүйцэтгэх захирал Ч.Төмөрбаатар – “Хүнд машин механизмын засварын техникч”

Менежер Ч.Батбаатар – “Аялал жуучлалын менежер”

Нягтлан Ж.Цэрэнханд – “Нягтлан бодогч”

Тосонцэнгэл сум дахь шалгагч механик Ц.Бумцэнд – “Техникч-механик” тээвэр зохицуулагч Ч.Дармаахүү

Засварчин Н.Цогтсайхан-“Агрегат засварчин” мэргэжилтэй;

Өөрийн өмчлөлийн Засвар үйлчилгээний байргүй. Тухайн компани Тосонцэнгэл суманд Засаг даргын 2014.04.25-ны өдрийн А/41 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж, талбарын 120502254 дугаар бүхий 5600 м²/га/ газрыг 15 жилийн хугацаатай “Автобусны үйлчилгээ, парк” зориулалтаар эзэмших эрхтэй. Газрын гэрчилгээний №000299907. Энэ газар дээр ЗҮБ барих зураг төсөл хийж байна. Өнөөдрийн байдлаар Засвар үйлчилгээг “Мон тээвэр сервис” ХХК-тай гэрээ байгуулан УБ хотод хийж байна. Тосонцэнгэл суманд иргэн Б.Цогтбаатартай дулаан гарааш эзэмших гэрээ байгуулан ажиллаж байна.

❖ “Дорнын саруул зам” хоршоо

Дарга Ц.Алтанням – Автотээврийн хэрэгслийн засварчин

Засварын инженер – Г.Доржжигжид/Автомашин ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр зөвлөх инженер/ шалгах механикч, тээвэр зохицуулалтын ажлыг хавсран гүйцэтгэдэг.

Өөрийн өмчлөлийн Засвар үйлчилгээний байргүй. Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн дулаан гараашийг эзэмшдэг.

Зургаа. Дүгнэлт

❖ **“Жигд эргэлт” ХХК**

1. “Жигд эргэлт” ХХК-д хийсэн гүйцэтгэлийн хяналт шалгалтаар тухайн компани “их эрсдэл”-ээ “дунд эрсдэл”-д шилжүүлж бууруулсан байна. Тодруулбал: “Жигд эргэлт” ХХК-ийн өмнөх шалгалтаар тогтоосон эрсдэлийн үнэлгээнд тодотгол хийхэд 123 оноо авч, 44,6%-тай “Дунд эрсдэлтэй” гэж дүгнэгдлээ;

2. “Жигд эргэлт” ХХК нь шаардлагатай ажлын байранд мэргэжлийн албан тушаалтан нарыг томилон ажиллаж, шугам замд ажиллах тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөл шаардлага хангасан эсэхийг шалгаж, хэвшсэн;

3. Автомашин ашиглалттай холбоотой асуудлыг хянан шийдвэрлэж байх үүрэг бүхий техникийн комиссыг байгуулж, ажиллах журмыг тогтоон ажилласан;

4. Тээврийн хэрэгсэлд хийх техник үйлчилгээ 1, 2 болон улирлын үйлчилгээг тээврийн хэрэгслийн бодит гүйлтэд тулгуурлан гэрээт засварын газар болох “Мон тээвэр сервис” ХХК-ийн байранд хийж, хэвшсэн;

5. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум, дундын эмнэлгийн эмч Ц.Нарантуяатай “Хамтран ажиллах” гэрээг байгуулан жолооч нарыг эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт хамруулан, шугамд гарахын өмнө тээврийн хэрэгсэл жолоодох чадварын эмчийн үзлэгт хамруулдаг болсон байна.

❖ “Дорнын саруул зам” хоршоо

“Дорнын саруул зам” хоршооны эрсдэлийг МХЕГ-ын даргын 2015 оны 12 дугаар тушаалаар баталсан 5.21 кодтой Нийтийн тээврийн байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад 113 оноо авч 39,3%-иар “дунд эрсдэлтэй” гэж дүгнэгдлээ.

Шалгалтад хамрагдсан байгууллагуудад Автотээврийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг тооцоход “Жигд эргэлт” ХХК-62,5%, “Дорнын саруул зам” хоршоо-60,5%-тай дунджаар 61,5%-иар хэрэгжүүлэн ажиллаж байна гэж дүгнэгдлээ.

Танилцсан:

ЗТЯ-НЫ ХШУДАГ-ЫН ДАРГА

П.БИЛГҮҮН

Танилцуулга бичсэн:

ЗТЯ-НЫ ХШУДАГ-ЫН ЗТХХ-ИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОЮУНТУНГАЛАГ

МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНЦЭЦЭГ

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ГАНБОЛД